

## Монголын бүх ард түмний спортын 15 наадам Дундговь аймгийн насанд хүрэгчдын шатрын аварга шалгаруулах тэмцээний тайлан

2022.03.14

Аймгийн аварга шалгаруулах шатрын тэмцээн 2022 оны 3 сарын 12-13-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж өндрөллөө. Тэмцээнд Аймгийн Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн С.Цолмон, аймгийн шатрын холбооны нарийн бичиг М.Билгүүн, Монголын шатрын холбооны ЕНБД [Батсайхан Цэрэндорж](#), Боловсрол шинжлэх ухааны яамны санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, аймгийн шатрын холбооны УЗ гишүүн О.Хуягцогт, аймгийн шатрын холбооны тэргүүн С.Сүхбаатар нар нээж үг хэллээ. Спортын дэд мастер цолоор А.Найгалмаа, С.Сэргэлэн нар шагнагдаж МШХ-ны ЕНБД Ц.Батсайхан шагналыг гардуулж баяр хүргэлээ.

Тэмцээний нээлтийн үйл ажилгааны урлагын номер Тэнгэрийн тэмдэг хүүхэлдэйн театрын дуучин, хөтлөгч нар оролцлоо.











Тэмцээнд нийт эрэгтэй 25 эмэгтэй 14 шатарчин оролцсон ба спортын мастер 3 спортын дэд мастер 2 спортын 1 дүгээр зэрэгтэй 14 шатарчин өрсөлдөж эрэгтэй ангилал

Тэргүүн байр СМ Х. Итгэлт Шатрын холбоо

Дэд байр СМ О. Билэгсайхан Шинэ шийдэл клуб

Гутгаар байр СМ Д. Санжмятав Сайнцагаан сум

Эмэгтэй ангилал

Тэргүүн байр [Т. Урангоо](#) Шинэ шийдэл клуб

Дэд байр ДМ А. Найгалмаа Шинэ шийдэл клуб

Гутгаар байр Б. Нандинжаргал Шинэ шийдэл клубын шатарчид тус тус байр эзэллээ.

Хамтран ажилласан БТСГ, ТТХТ-н нийт хамт олонд талархал илэрхийлье.



Тэмцээний хаалтын үйл ажиллагаанд МШХ-ны ЕНБД Ц.Батсайхан, Биеийн тамир, спортын газрын дарга А.Отгонбаатар, Спортын мастер ахмад шатарчин Д.Санжмятав нар аймгийн аварга шатарчдад алт, мөнгө, хүрэл медаль өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулж тэмцээнийг МШХ-ны ЕНБД Ц.Батсайхан хааж үг хэллээ.

Тайлан бичсэн мэргэжилтэн

С.Цолмон